



МОНГОЛ УЛС  
САНХҮҮГИЙН ЗОХИЦУУЛАХ ХОРООНЫ  
ТОГТООЛ

2013 оны 10 сарын 22 өдөр

Дугаар 365

Улаанбаатар хот

Хорооны 2012 оны 393 дугаар тогтоолоор  
батлагдсан зааварт өөрчлөлт оруулах тухай

“Санхүүгийн зохицуулах хорооны эрх зүйн байдлын тухай хууль”-ийн 6.1.2, “Жолоочийн даатгалын тухай хууль”-ийн 12<sup>1</sup>.7 дахь заалтыг тус тус үндэслэн Санхүүгийн зохицуулах хорооноос ТОГТООХ нь:

1. Санхүүгийн зохицуулах хорооны 2012 оны 12 дугаар сарын 26-ны өдрийн 393 дугаар тогтоолоор батлагдсан “Жолоочийн даатгалын сангаас нөхөн төлбөр олгох заавар”-ын 4 дүгээр зүйлийн 4.1 дэх хэсэг, 5 дугаар зүйлийн 5.1 дэх хэсгийг дараах байдлаар өөрчлөн нийруулсугай;

1/. 4 дүгээр зүйлийн 1 дэх хэсэг:

“4.1. Даатгалын сангийн хэлтэс нь нөхөн төлбөрийн материал бүрэн бүрдэж, нөхөн төлбөр олгох үндэслэлтэй гэж үзвэл нөхөн төлбөр олгох саналаа Захиргаа хуулийн хэлтсээр хянуулж, гүйцэтгэх захиралд танилцуулах бөгөөд гүйцэтгэх захирал нөхөн төлбөр олгох эсэх асуудлыг эцэслэн шийдвэрлэнэ.”

2/. 5дугаар зүйлийн 1 дэх хэсэг

“5.1. Захиргаа хуулийн хэлтэс нь “Жолоочийн даатгалын тухай хууль”-ийн 20.2-т заасан хохирогчид олгосон төлбөрийг буруутай этгээдээс буцаан нэхэмжлэх эрхийн хүрээнд олгосон нөхөн төлбөрийг барагдуулах арга хэмжээг авч, шүүхэд нэхэмжлэл гаргана.”

2. Санхүүгийн зохицуулах хорооны 2012 оны 12 дугаар сарын 26-ны өдрийн 393 дугаар тогтоолоор батлагдсан “Жолоочийн даатгалын сангаас нөхөн төлбөр олгох заавар”-ын 4 дүгээр зүйлийн 4.2, 4.3, 4.4, 4.5 дахь хэсэг, 5 дугаар зүйлийн 5.2 дахь хэсэг болон мөн зааврын 1, 2, 3 дугаар хавсралтыг тус тус хүчингүй болгосугай.

3. Зааварт өөрчлөлтийг тусгаж, хэрэгжилтэд хяналт тавин олон нийтэд мэдээлэж ажиллахыг Ажлын алба /Х.Бум-Эрдэнэ/-нд даалгасугай

ДАРГА



Д.БАЯРСАЙХАН

ДААЛГАСУГАЙХАН  
Д.БАЯРСАЙХАН